

## **ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ**

Сайн Байцгаана уу,

ОУДС-ийн хамт олон бид олон арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөөд байна. Энэ амралтын өдрүүдэд Стратеги Төлөвлөлтийн багийхан Үйл Ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сургалтанд оролцоно. ОУДС-ийн Авъяастнуудын Тоглолтыг бид 5 сарын 21-ны Баасан гарагийн орой 7:00 цагт зохион байгуулна. Төгсөлтийн баяр 5 сарын 28-ны Баасан гарагт болно. Хичээлийн жил 6 сарын 17-нд дуусна.

Энэ хичээлийн жилийн сүүлийн “Захирлын Өглөөний Кофе” уулзалтыг 5 сарын 21-ний Баасан гарагийн өглөө 8:20-д би зохион байгуулна. Та бүхэн энэ уулзалтанд оролцож цай кофе уунгаа бусад эцэг эхчүүд болон сургуулийн удирдлагуудтай уулзаж ярилцаарай. Стратеги зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар би товч мэдээлэл хийнэ. Та бүхнийг энэ уулзалтанд хүрэлцэн ирэхийг урьж байна.

Ирэх жил бид сургуульдаа хэд хэдэн лаптоп, нэт бүүк хэрэглэх гэж байна. Номын сангийн хэрэгцээнд болон Дизайн Технологийн хичээлд зориулж хэд хэдэн шинэ лаптоп худалдаж авна. Зөөврийн нэт бүүкүүдийг ангиудад хэрэглэх болно. Бид шинээр мэргэжлийн, туршлагатай номын санч ажилд авсан бөгөөд номын санч маань ч танхимд технологийг түлхүү ашиглахад анхаарах болно. Номын санч маань кино дугуйлан ажиллуулж сурагчдад богино хэмжээний болон баримтат кино хийх сургалт явуулна.

Бүртгэлийн болон төлбөрийн мэдээллийн хуудсууд та бүхний гар дээр очсон байгаа. Эдгээр хуудсуудыг бөглөж бидэнд ирүүлээрэй. Бүртгэлийн хураамж төлбөрийг төлсөнөөр та бүхэн ОУДС-д хүүхдээ сургах орон тоог баталгаажуулах болно.

Цэцэрлэгийн ангийн хувьд ирэх жил бага зэрэг өөрчлөлт орсон. ОУДС гурван настай хүүхдийн ангид элсэлт авахгүй. Цэцэрлэгийн ангид зөвхөн дөрвөн нас хүрсэн сурагчдыг элсүүлнэ. Энэ анги бүтэн өдрийн сургалттай анги байх болно.

Та бүхэнтэй ирэх Баасан гарагт уулзацгаая.

Та бүхнийг хүндэтгэсэн,

**Захирал Greg Rayl**

### **Хуанлид тэмдэглэх өдрүүд:**

<b>5-р сарын 18</b>	PTG-н уулзалт. Номын санд орой 7 цагт
<b>5 сарын 21</b>	<b>Захирлын Өглөөний Кофе уулзалт</b>
<b>5-р сарын 21</b>	“Creative Arts” үдэш
5 сарын 27	Төгөлдөр Хуурын дугуйлангийн сурагчдын тоглолт
5 сарын 28	Төгсөлтийн Баяр

### **2010-2011 оны хичээлийн жилийн элсэлтийн талаар:**

Ирэх хичээлийн жилд сургуульдаа эргэж ирж суралцана гэдгээ мэдэгдсэн сурагчдын эцэг эхчүүд Бүртгэлийн болон Төлбөрийн мэдээллийн хуудсыг 5 сарын 21-ний дотор анги удирдсан багш нарт ирүүлнэ үү. Бид эдгээр хуудсуудыг хүлээж авмагц төлбөрийн нэхэмжлэлийг та бүхэнд илгээх болно. ОУДС-д хүүхдээ сургах орон тоог баталгаажуулахын тулд бүртгэлийн төлбөр, хураамжийг 2010 оны 6 сарын 1-ний дотор төлөх хэрэгтэй.

Ирэх жил манай сургуульд хүүхдээ сургах эсэхээ бидэнд хараахан мэдээлээгүй байгаа эцэг эхчүүд байвал бидэнтэй яаралтай холбоо бариарай. Бид одоо шинээр элсэгчдийн материалыг хүлээж авах гэж байна.

## **БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

Цаг агаар дулаарсан тул хэд хэдэн ангийн сурагчид хичээлийн сэдвийн хүрээнд Туул гол руу явган аялал хийлээ.

**Ариун Цэврийн Талаар:** Та бүхэн хүүхдүүдээ гараа сайтар угаах талаар тогтмол сануулж байгаарай. Учир нь Улаанбаатар хотод гар хөл амны өвчний хэд хэдэн халдвар гарсан тохиолдол гарлаа.

**Бага Сургуулийн Эрхлэгч Jan Wiggins**

### **Гурил Будаа Цуглуулах Хандивын Аян**

5-р ангийн сурагчид хэд хэдэн бүлэгт хуваагдаж үзэсгэлэндээ бэлтгэж байгаа билээ. Ядуу амьдралтай ахмадуудад туслах бүлгийн гишүүн сурагч Jiamian, Амраа, Анужин, Танхилуун нар Мягмар гарагт Dolma Ling халамжийн төвийн гал тогоонд зочиллоо. Энэ хамт олон гэр оронгүй, ядуу хүмүүсийг хооллодог юм. Санхүүжилт багатай болохоор тэд хэрэгцээгээ хангахуйц хэмжээний хоол хүнсийг авч чаддаггүй учир биднээс тусламж хүссэн юм. Энэ төвийн хамт олонд гурил, будаа хандивлавал тэд олон хүнийг хооллох боломжтой болно. Иймээс бид нийт сургуулийнхаа хамт олны дунд гурил, будаа, мөнгө цуглуулж эдгээр хүмүүст туслах аяныг өрнүүлэхээр шийдсэн юм. Та бүхэн хандивын зүйлсээ 5-р ангид байгаа хайрцганд авчирч хийх буюу анги удирдсан багш нартаа хураалгаж болно. Хандив цуглуулах сүүлчийн хугацаа 5 сарын 21-ний Баасан гараг. Та бүхэнд баярлалаа!

**5-р ангийн сурагч Jiamian Нuo**

### **ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

Хавар болж салхилан цаг агаар хуурайшилт ихтэй байгаа тул та бүхэн хүүхдүүдээ ус сайн уулгаж салхи шорооноос хамгаалах хүрэм өмсгөж явуулаарай. Сурагчид өдөр бүр хичээлдээ өөрсдийн усны савтай ирвэл сайн байна.

Төгсөх ангийн сурагчид маань шалгалтуудаа өгч эхлээд 2 долоо хоног болж байна. Та бүхэн тэднийг зөв хооллож, сайн унтаж, цагаа зөв хуваарилахад нь тусалж дэмжээрэй. ИВ дипломын шалгалтандаа сурагчид маань сайн бэлтгэж байгаа гэдэгт бид итгэлтэй байгаа бөгөөд тэд цагаа зөв зохицуулж ажиллавал шалгалтаа амжилттай өгөх болно.

Бид энэ амралтын өдрүүдэд стратеги төлөвлөлтийн 2-р шатны сургалтыг зохион байгуулах гэж байна. Сургалтын үр дүнд бид ирэх 5 жилийн хэтийн төлөвлөгөөг боловсруулан гаргаснаар энэ нь сургуулийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх болно. Та бүхэн Удирдах Зөвлөлийн гишүүдээс сургуулийн хэтийн төлөвлөгөөний талаар асууж ярилцаарай.

**Дунд Сургуулийн Эрхлэгч Betsy Hanselmann**

### **ОУДС-ийн Залуу Аялагчдын Клуб**

5 сарын 8-ны Бямба гарагт 8-р ангийн 7 сурагч Богд Ууланд хийсэн Залуу Аялагчдын Клубын явган аялалд оролцлоо. Явган аялал 2 цаг үргэлжилж аялагчид уулын нарийн зөрөг хад, чулуутай замаар салхи сөрөн алхсан. Энэ аялал нь 3 удаа зохиогдох явган аялалын эхнийх нь байсан бөгөөд 3 дахь аялалын төгсгөлд тэд хоногоор аялах болно. Монгол орон аялал зугаалга хийхэд тохиромжтой нутаг бөгөөд Залуу Аялагчдын Клубын зорилго нь сурагчдад байгалийн өвөрмөц орчинг мэдрүүлж байгаль орчноо хайрлаж хамгаалах үзлийг төлөвшүүлэхэд оршино.

Энэ аялалд наймдугаар анги болон түүнээс дээш ангийн сурагчид оролцох боломжтой. Хэрвээ хүүхэд тань явган аялалд оролцох хүсэлтэй бол та бүхэн бидэнтэй [d.chillton@isumongolia.edu.mn](mailto:d.chillton@isumongolia.edu.mn) хаягаар холбоо бариарай.

### **ЭББ-ийн мэдээ**

ЭББ 5 сарын 21-ний Баасан гарагт Creative Arts Evening арга хэмжээний үеэр жигнэмэгийн худалдаа зохион байгуулна. Хэрвээ та бүхэн жигнэсэн бүтээгдэхүүн хандивлах буюу энэ арга хэмжээнд туслах хүсэлтэй бол Michele Moller-той [michelemoller@yahoo.com](mailto:michelemoller@yahoo.com) хаягаар холбоо бариарай. Та бүхэн жигнэмэг болон хөнгөн зуушаа 5 сарын 21-нд боломжтой цагтаа ресепшин дээр ирүүлэх буюу оройн арга хэмжээнд ирэхдээ авчирч болно.

ЭББ-ийн хурал 5 сарын 18-ны Мягмар гарагийн орой 7:00 цагт ОУДС-ийн номын санд болно. Энэ хурлаар ирэх жилийн Намрын Баярын төлөвлөгөөг хэлэлцэнэ. Мөн хурлаар шинэ хичээлийн жилд ажиллах ЭББ-н гишүүдийг сонгох талаар ярилцана. Та ЭББ-н ажилд тусалж оролцож амжаагүй ч гэсэн энэ хуралд заавал ирж оролцоорой.